

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЦАГДААГИЙН ГАЗАР

2024.01.04

Өлгий сум

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН
2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг: Удирдлага, зохион байгуулалтын талаар

1.1. Цагдаагийн газраас 2023 онд хуулиар хүлээсэн гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, онц чухал объектыг хамгаалах чиг үүргээ шалгуур үзүүлэлтийн түвшинд хэрэгжүүлж, иргэдийн аюулгүй орчинд амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэн ажилласан.

1.2. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны А/01 дүгээр тушаалаар баталсан Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2023 онд дэвшүүлсэн зорилт, шалгуур үзүүлэлт, Цагдаагийн ерөнхий газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг зохих түвшинд хэрэгжүүллээ.

1.3. Үйл ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хангаж, хууль сахиулах үйл ажиллагааг нэг мөр хэрэгжүүлэн, хүний нөөцийг бүрдүүлэх, алба хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, мэдлэг, ур чадвар, сахилга, ёс зүй, хариуцлагыг дээшлүүлэх, дэвшилтэд техник технологийг нэвтрүүлэх зэрэг олон талт ажил, арга хэмжээг зохион байгууллаа.

2024 оны зарим онцлог ажлуудаас дурдвал:

1.4. Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн нэрэмжит ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох гуравдугаар шатны үзлэгээр Цагдаагийн газар 80.63 хувь буюу “Сайн” үнэлэгдсэн.

1.5. Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын 2023 оны хянапт шалгалтын хуваарийн дагуу Цагдаагийн газрын үйл ажиллагаанд төлөвлөгөөт бүрэн шалгалт хийж, “Хангалттай” үнэлгээ өгсөн.

1.6. Алба хаагч, ажилчдыг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт бүрэн хамруулсан.

1.7. Санхүү, ар талын албаны “Сүүж-уул” амралт, сэргээн засах сувилалд нийт 50 алба хаагч, ажилтан, гэр бүлийн гишүүд, ахмад ажилтныг хамруулах ажлыг зохион байгуулсан.

1.8. Цагдаагийн ерөнхий газрын даргын 2023 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/263 дугаар тушаалаар “Улаанхус сумын цагдаагийн хэсэг”-ийг “Цэнгэл сумын сум дундын цагдаагийн тасаг” болгон өөрчлөн байгуулж, тус аймгийн Сагсай, Улаанхус сумын хэсгийн төлөөлөгч, цагдаа зэрэг нийт 10 алба хаагчийг тус цагдаагийн тасагт хариуцуулсан бөгөөд цаашид Дэлүүн суманд “Сумын сум дундын цагдаагийн тасаг” байгуулахаар төлөвлөсөн.

1.9. Цагдаагийн ерөнхий газраас 2023 онд 1, орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2, нийт 3 авто машины парк шинэчлэл хийсэн.

- Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн санхүүжилтээр тус Цагдаагийн газарт 1 ширхэг нисдэг камер худалдаж авахаад шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэж нийлүүлсэн.

- Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс Цагдаагийн газрын автомашинуудад байршуулах 6 ширхэг камер худалдаж авахад шаардагдах 3.500.000 төгрөгний санхүүжилтийг шийдвэрлэсэн.

- Аймгийн Засаг даргын тамгын газраас 1 ширхэг нөтбүүк, 5 ширхэг хэвлэх төхөөрөмж олгосон.

1.10. Сумын Засаг дарга нар хэсгийн төлөөлөгч, хэсгийн цагдаа нарын үйл ажиллагааг дэмжих, тоног төхөөрөмж худалдан авах, ажиллах орчин нөхцөлийг сайжруулж зорилгоор 70 орчим сая төгрөгний санхүүжилтийг шийдвэрлэсэн.

1.11. Төвлөрсөн дулааны шугамд 2 сумын цагдаагийн кобаныг холбосноор, нийт 8 сумын цагдаагийн кобан төвлөрсөн дулааны шугамд холбогдоод байгаа ба цаашид үлдсэн сумын цагдаагийн кобаныг төвлөрсөн дулааны шугамд холбох ажлыг Засаг дарга нартай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

1.12. Энэ жил Алтанцөгц сумын хэсгийн төлөөлөгчид авто машин олгосноор нийт 9 сумын хэсгийн төлөөлөгч авто машинтай болсон.

1.13. Өлгий-Ховд-Цагааннуур чиглэлийн А/0305, А/0306 дугаартай авто зам дагуу Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор 4 ширхэг постын байр хийхэд шаардагдах санхүүжилт болох 51.000.000 төгрөгийг Азийн хөгжлийн банкаар шийдвэрлүүлэн хөрөнгө оруулалтыг “Лаулау” ХХК ажлыг гүйцэтгэж, 2023 оны 02 дугаар сарын 10-ны өдөр ашиглалтад хүлээлгэн өгсөнөөр алба хаагчдын ажиллах орчин нөхцөл сайжирсан.

1.14. “Цагааннуур” чөлөөт бүс улсын онц чухал объектын харуул хамгаалалтыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд харуул, хамгаалалтыг сайжруулах зорилгоор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 192 дугаар тогтоолоор нийт 15 ширхэг хяналтын камер худалдан авахад шаардагдах 20.000.000 төгрөгний санхүүжилтийг шийдвэрлэсэн.

Хоёр: Хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн талаар

2.1. Цагдаагийн газар гэмт хэрэг, зөрчлийн талаарх 3399 гомдол, мэдээлэл шалгасан бөгөөд үүнийг өнгөрсөн жилтэй харьцуулахад 8 гомдол, мэдээлэл буюу 0.2 хувиар буурсан.

- Нийт 371 холбогдогчтой, 896.9 сая төгрөгний хохиролтой, 407 гэмт хэрэгт хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан.

- Гэмт хэргийг 2022 онтой харьцуулахад 94 гэмт хэрэг буюу 30.3 хувиар өссөн.

- Гэмт хэргийн илрүүлэлтийг 74.2 хувьд хүргэсэн бөгөөд үүнийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 2.3 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа нь гэмт хэрэг өсөхөд нөлөөлсөн нэг хүчин зүйл болсон.

- Цагдаагийн газраас нийт 501 тооны хүн, мал, эд зүйл, амьтанг эрэн сурвалжилснаас 370 тооны хүн, мал, эд зүйлийг олж тогтоон эрэн сурвалжлалтыг зогсоосон.

- Тайлангийн хугацаанд 30.292 зөрчил илрүүлсэн бөгөөд үүнийг өнгөрсөн жилийн мөн үетэй харьцуулахад 9249 зөрчил буюу 43.9 хувиар өссөн байна.

- Хариуцсан нутаг дэвсгэрт жагсаал, цуглаан зохион байгуулагдаагүй, олон нийтийн хамарсан 38 удаагийн арга хэмжээний хамгаалалтад давхардсан тоогоор 730 алба хаагч 106 тээврийн хэрэгсэлтэй, 814 цагийн үүрэг гүйцэтгэсэн ба арга хэмжээнд давхардсан тоогоор 80.642 гаруй хүн хамрагдсан.

1: Сумдад бүртгэгдсэн гэмт хэрэг

№	Сумын нэр	Бүртгэгдсэн гэмт хэрэг		Өсөлт, бууралтын хувь	Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 10.1	Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг 11.1-11.7	Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг	Үүнээс		Малын хулгай	Хүчингийн хэрэг 12.1	Дээрэмдэх	Залилан мэхлэх	Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	Бусад
		2022 он	2023 он					Тээврийн хэрэгслийн хулгай	Халаасны хулгай							
1	Алтай сум	13	6	7/-53.8%										1		5
2	Алтанцөгц сум	7	10	3/42.8%		2	1		1				1	1		4
3	Баяннуур сум	15	12	3/-20.0%		2	3	3	1	1			1			4
4	Бугат сум	11	10	1/-9.0%		2	2						3	1		2
5	Булган сум	7	6	1/-14.2%		3	2		1							
6	Буянт сум	13	15	2/15.3%		3	3		3				1			5
7	Дэлүүн сум	11	12	1/9.0%		6				1		2				3
8	Ногооннуур сум	19	9	10/-52.6%		4								1		4
9	Сагсай сум	10	13	3/30.0%		3	3		1				1			5
10	Толбо сум	9	6	3/-33.3%		1	3			1						1
11	Улаанхус сум	17	11	6/-35.2%		1	2		1	1	1	3				2
12	Цэнгэл сум	16	18	2/12.5%		11	3		1				1			2
13	Өлгий сум	165	279	114/69.0%	1	68	46	1			5	2	92	5		60
Дүн		313	407	94/30.0%	1	106	68	4	9	9	3	105	9			97

- Хариуцсан нутаг дэвсгэрийн гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэж болзошгүй 98 эмзэг цэгийг объект, гэмт хэрэг зөрчил үйлдэж болзошгүй 436 субъектыг судалгаанд авсан.

- Эргүүлийн хяналтаар 7 гэмт хэрэг, 5146 зөрчил илрүүлснээс 4993 зөрчилд хялбаршуулсан журмаар 160.652.550 төгрөгийн торгууль оногдуулж, 410 зөрчлийг шалгуулахаар эрх бүхий албан тушаалтанд шилжүүлсэн.

- 2023 онд тус аймагт ирсэн гадаад, дотоодын нийт 60.000 гаруй жуулчдын аюулгүй байдлыг хангасан.

- Аймгийн нутаг дэвсгэрт 2023 онд өссөн үзүүлэлттэй бүртгэгдсэн гэмт хэрэг:
 - хулгайлах гэмт хэрэг-68,
 - залилах гэмт хэрэг-105,
 - хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг-106,
 - хүүхэд оролцсон гэмт хэрэг-37,
 - согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг-42,

Дээрх 5 төрлийн гэмт хэргийн нийт бүртгэгдсэн 407 гэмт хэргийн 87.9 хувийг эзэлж байгаа нь цаашид дээрх төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэхийг хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

- 28 удаагийн нэгдсэн,
- 11 удаагийн хэсэгчилсэн,
- 18 удаагийн нэгдсэн үзлэг шалгалт,
- 68 удаа уулзалт, хэлэлцүүлэг, ярилцлага,
- 498 удаагийн сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулсан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

- Аймгийн Засаг даргын 13 захирамж,
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2 тогтоол,
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн 4 тогтоол,
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын 2 тушаал,
- Сумдын Засаг дарга нарын 21 захирамж,

- Сумдын ИТХ-ын 9 тогтоол,
- Эрх бүхий албан тушаалтны 23 тушаал, нийт 72 шийдэврийг гаргуулсан.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх чиглэлээр:

- Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлөөс 55.100.00 төгрөг,
- Аймгийн Засаг даргын нөөц болон замын сангийн хөрөнгөөс 40.988,000 төгрөг,
- Дэлхийн байгаль хамгаалах сангаас 3.500.000 төгрөг,
- Сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал болон орон нутгийн сум хөгжүүлэх сан, Засаг даргын нөөц хөрөнгөөс 24.500.000 төгрөг, нийт 124.088.000 төгрөгийг шийдвэрлүүлсэн.
- Аймгийн төв Өлгий суманд 48 цэгт 104, 11 сум, 1 тосгоны төвд 85, дундаж хурдын 16, нийт 205 хяналтын камерын тусламжтайгаар 7 гэмт хэрэг, 1347 зөрчил илрүүлсэн.
- “Ногоон бүс” төслийн хүрээнд аймгийн төв Өлгий сумын 5, 11 дүгээр багийн нутаг дэвсгэрийн 14 цэгт 20 ширхэг хяналтын камер байршуулсан.
- Аймгийн төв Өлгий суманд нэвтрэх 6 байршилд 16 хяналтын камер суурилуулсан.
- “Цагааннуур-Улаанбайшинт” чиглэлийн авто замд дундаж хурдны 16 ширхэг теле хяналтын камер суурилуулахад шаардагдах 212.938.000 төгрөгний Азийн хөгжлийн банкаар шийдвэрлүүлсэн бөгөөд хөрөнгө оруулалтыг “Оргил Дельта” ХХК гүйцэтгэж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр ашиглалтанд оруулсан.
- 2023 онд нэг суманд шинээр, хоёр суманд хяналтын камерын өргөтгөл хийснээр 11 сум, 1 тосгоны төвийг хяналтын камерын нэгдсэн төвд холбогдох ажлыг хэрэгжүүлсэн.
- Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран Оросын Холбооны Улстай хил залгаа Ногооннуур, Улаанхус сум болон Цагааннуур тосгоны малчдын 13 азарга сүрэг адууг 8.151.000 төгрөгийн үнэ бүхий GPS төхөөрөмжтэй болгож, адуу малын хөдөлгөөнийг гэрээсээ хянах боломжийг бүрдүүлсэн нь үр дүнтэй ажил болсон.
- Цаашид 12 сум, 1 тосгоны 2024 оны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөнд малчдын адуу малыг GPS төхөөрөмжтэй болгох чиглэлээр тодорхой заалт оруулж, санхүүжилтийг орон нутгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн төсөвт суулгуулахаар төлөвлөсөн.
- Хилийн цэргийн 0285 дугаар ангитай хамтран хилийн бүсийн Ногооннуур, Улаанхус сумын иргэдийн малын зүс, им, тамга, нас, хүйс, тоо толгойг бүртгэж, мэдээлэл солилцох 5 сая төгрөгийн “Сүлд-23” динамик бүтцийн веб программ буюу цахим бүртгэлийн сан үүсгэх ажлыг зохион байгуулж эхэлсэн.
- Дотоодын цэргийн алба хаагчид:
 - Харуулд 7560 цагийн үүрэг гүйцэтгэж,
 - объектод байнгын үнэмлэхээр нэвтэрсэн 948 иргэн,
 - гаднаас нэвтэрсэн 472 иргэн,
 - 142 тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу шалган нэвтрүүлж, 9625 удаагийн бусад хөдөлгөөнийг бүртгэж, нийт 11187 удаагийн хөдөлгөөнд хяналт тавьж, зөрчил дутагдалгүй ажилласан.
- Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж хохирсон 45 хүнд “Нэг цэгийн үйлчилгээний төв”-өөр дамжуулан гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан үйлчилгээ үзүүлэн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгааллаа.
- Аймгийн хэмжээнд “Эрүүл зан үйлийг дэмжсэн Архидалтгүй аймаг-Баян-Өлгий-2”, “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах” дэд хөтөлбөрийг хэрэгжүүллээ.

- Улсын хэмжээнд зохион байгуулагдсан:

1. “Эко-2023” нэгдсэн арга хэмжээний үр дүнгээр 1 дүгээр байр,
2. “Тэрбум мод” /хавар/ үндэсний хөдөлгөөний хүрээнд идэвх санаачилага гаргаж ажлын үр дүнгээр улсын хэмжээнд 1 дүгээр байр,
3. “Нэг зам-нэг соёл” аяны үр дүнгээр 2 дугаар байр,
4. “Хүн бүр байгаль хамгаалагч” аяны үр дүнгээр 3 дугаар байранд тус тус шалгарсан.

Гурав: Бусад ажлын талаар

3.1. Сүхбаатарын болон Байлдааны гавьяаны улаан тугийн одонт Цагдаагийн албаны туг, Сүхбаатарын болон Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Дотоодын цэргийн байлдааны туганд хүндэтгэл үзүүлэх, “Цагдаагийн тангараг” давтах ёслолын арга хэмжээг 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Баян-Өлгий аймгийн Өлгий сумын төв Монгол Улсын баатар М.Икейн нэрэмжит төв талбайд зохион байгуулсан.

3.2. Цагдаагийн газрын 2023 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/25 дугаар тушаалаар ахмад ажилтнуудад 4.180.000 төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлж, гарын бэлэг гардуусан.

- Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны “Ахмадын байгууллага, ахмад настны талаар авах арга хэмжээ /код 947/ журам”-ын хэрэгжилтийг хангах зорилгоор Цагдаагийн газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн Б/59 дугаар тушаалаар 7 ахмад ажилтанд 1.159.000 төгрөгний дэмжлэг үзүүлсэн.

3.3. Бүгд Найрамдах Турк Улс, Арабын Бүгд Найрамдах Сири Улсын ард иргэдэд сэтгэлийн дэм өгөх, хандив тусламж үзүүлэх ажлыг Цагдаагийн газрын хэмжээнд зохион байгуулсан.

АМАР ТАЙВАН АМЬДРАЛЫН ТӨЛӨӨ ХАМДТАА...

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЦАГДААГИЙН ГАЗАР